



ҮАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



“БАТАЛГАА АУДИТ” ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО” ХХК

2016 оны санхүүгийн тайланд
хийсэн аудит

Улаанбаатар хот
2017 он



Нягтлан Бодох Бүртгэл Хяналтын Хараат бус Хөндлөнгийн Итгэмжлэгдсэн Байгууллага

“БАТАЛГАА АУДИТ” ХХК

20 17 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 197

Монгол улс, Улаанбаатар хот,
БЗД, 15-р хороо, 13-р хороолол,
ЭТӨЧ, “Channel center” 204 тоот

“АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ О.ЭРДЭНЭГЭРЭЛ ТАНАА

Хараат бус аудиторын
тайлан

Бид “АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО” ХХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болсон жилийн Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд, бусад нэмэлт тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланг шалгалаа.

Санхүүгийн тайланд холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартын хүрээнд эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдааны улмаас гарч болох материаллаг буруу тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Аудиторын хүлээх хариуцлага

Хийж гүйцэтгэсэн шалгалт дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний үүрэг юм. Бид энэхүү аудитын ажлыг Олон Улсын Стандартуудын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөн, санхүүгийн тайлангууд материаллаг алдаатай эсэх талаар ул үндэслэлтэй баталгаажуулалт олж авахын тулд аудитыг төлөвлөж гүйцэтгэхийг эдгээр стандартууд биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангуудын тоон үзүүлэлт болон тодруулгуудын дагалдах нотолгоог олж авах горимуудыг гүйцэтгэх ажил орно. Санхүүгийн тайлангууд алдаа эсвэл залилангийн улмаас гарч болох материаллаг буруу тайлагналтай байж болох эрсдлийг үнэлэх горимуудыг аудитор нь өөрийн шийдлээр сонгон авна.

Тэдгээр эрсдлийн үнэлгээг хийхэд байгууллагын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй эсэхэд аудитор дүгнэлт гаргах нь гол зорилго биш юм.

Мөн аудитын ажилд аудиторуудын анхаарсан тооцоо, шинжлгээ ба нягтлан бодох бүртгэлийн аргачлал зарчмуудыг баримтлах, түүнчлэн санхүүгийн тайлангуудийн ерөнхий толилуулгад үнэлэлт өгөх ажлууд хамаарагдсан болно.

Түүнчлэн аудитаар тухайн хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн зохистой байдал болон тооцооллын ул үндэслэл, мөн санхүүгийн тайлангуудын нийт толилуулгыг үнэлж үзэх ажлууд багтдаг.

Бидний олж авсан аудитын нотолгоонууд нь санхүүгийн тайлангийн нягтлах гэрээт ажлын баталгаажуулалтанд хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлж өгсөн гэдэгт бүрэн итгэлтэй байна.

Дүгнэлт

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар "АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО" ХХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулж байна.

Жич: Хараат бус аудиторын тайлан нь үйлчлүүлэгчийн Санхүүгийн тайлангийн СТ-1, СТ-2, СТ-3, СТ-4 тайлангуудад үндэслэгдсэн хавсралтуудын хамт хүчинтэй.

Захирал:



Н.Агваан
(Доктор, профессор, МНБ)